*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ГАНБОЛДЫН СОНОМЦЭВЭЭНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1. | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Төвийн даргын баталсан “ГУАБ нарын хариуцсан бүлэг болон газар, хорооны хуваарь”-ийн дагуу БТКУС-ын 70, 84, 85-р бүлгүүдэд хяналт тавьж, бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нарт заавар, зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Мөн 7 хоног бүрийн мягмар гарагт гарч буй алдаа болон шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоол, тушаал, шийдвэрийн талаар танилцуулж, зарим бараагаар мэргэжлийг хүнийг урьж авчран сургалт зохион байгуулж, мэдээ мэлээллийг түгээж, мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажиллаж байна.<br>Зарим тохиолдолд бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад бараануудын үнэлгээг дахин хянуулан ажиллалаа. Үүнд: БТКУС-ын 84-р бүлгийн бараа | 1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт бүрэн байршуулсан байна.<br>2. Судалгаа, дүн шинжилгээнүүдийг гаалийн бүрдүүлэлтийн, орлогын, | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, холбогдох хууль тогтоомж, журам зааврын хүрээнд бүрэн алдаагүй хийхэд ГУБ нарт дэмжлэг үзүүлэн, заавар чиглэлийг хуулийн хүрээнд өгч, хамтран ажиллахын зэрэгцээ дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>1. Төвийн даргын баталсан “БЦТ-ийн ГУАБ нарын 2025 онд хариуцан хяналт тавих барааны бүлгийн хуваарь”-ийн дагуу БТКУС-ын 01-05, 27-29, 72-73, 87.02, 88-89, 91-р бүлгүүдэд хяналт тавьж, бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нарт заавар, зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Мөн 7 хоног бүрийн мягмар гарагт гарч буй алдаа болон шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоол, тушаал, шийдвэрийн талаар танилцуулж, зарим бараагаар мэргэжлийг хүнийг урьж авчран сургалт зохион байгуулж, мэдээ мэлээллийг түгээж, мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажиллаж байна.<br>Хариуцсан бүлгийн хүрээнд БТКУС-ийн 8702 ангилагдах автобусны үнэ хянаж [redacted] дугаартай мэдүүлэгт үнийг дахин хянуулан 1,438,097.44 төгрөгийг нэмж төлүүлсэн.<br>Экспортын гаалийн бүрдүүлэлтийн явцад тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэхээр дараах арга хэмжээг авч | 2025.01.01-2025.06.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | болох 2 төрлийн бутлуур, 06-2151017-24-I30031 дугаартай мэдүүлгийг бичиг баримтын шалгалт хийсэн төлөвөөс үнэлгээ буцааж, УМС-аар үнийг дахин хянуулан 9,507,598.26 төгрөгийн татварыг нэмж төлүүлсэн. 03-2091017-24-I31783, 03-2091017-24-I31793, 03-2141016-24-I30403, 16-2161001-24-I305538 дугаартай мэдүүлгээр мэдүүлсэн сэнс, үнс холих, төхөөрөмж, экскаватор, экскаваторын шанаганы үнийг бичиг баримтын шалгалт хийсэн төлөвөөс үнэлгээ буцааж, дахин хянуулан нийт 61,489,283 төгрөгийн гаалийн болон бусад татварыг нэмж төлүүлсэн. НИЙТ-70,996,881 төг.<br>2. Төвийн даргын баталсан “ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарь” дагуу дараах судалгаа, дүн шинжилгээг ГУБ нартай хамтран хийлээ. Үүнд:<br>- Орлогын дүн шинжилгээг 2024 оны 1-р улирал, 4 болон 5-р сараар 3 удаа хийж, төвийн даргад хянуулан, мэдээллээр хангасан.<br>3. ЗҮГГ-ын дарга, холбоо баригч ГУБ нартай холбоотой байж, хамтарсан манифестын лавлагааг хурдан шуурхай гаргуулан хамтран ажиллаж байна. Үнийн дүн өндөртэй авахуулсан лавлагаанаас дурдвал: Митайм монголиа ХХК /ГХО/-ны 4 мэдүүлгээр /6 автомашин/ мэдүүлсэн бараанд | горимын, хөнгөлөлт чөлөөлөлтийн гэх мэт олон чиглэлээр хийж, удирдлагыг мэдээллээр ханган, бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагааг сайжруулсан байна.<br>3. Гаалийн газар, хороодын удирдлагуудтай харилцан мэдээлэл, солилцож, хамтран ажилласан байна. | ажиллалаа. Үүнд:<br>- Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 380 "Техникийн зохицуулалт батлах тухай" тогтоолын хавсралтаар “ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг баталж, 2025 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Дээрх тогтоолын 2.5-д Экспорт, импортын зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх ямааны ноолуур нь дараах шаардлагыг хангасан байна: 2.5.1.хялгас болон завсрын үсний агууламж 0.3 хувиас ихгүй; 2.5.2.тослог 1.0 хувиас ихгүй; 2.5.3.чийглэг 17 хувиас ихгүй гэж зааж өгсөн.<br>Иймд БТКУС-ын 5105.31.10 кодод ангилагдах ямааны ноолуурыг гаалийн бүрдүүлэлтийн явцад лабораторийн шинжилгээнд хамруулах шаардлага тулгарч байгаа талаар ГЕГ-ын ЭУХ-т 2025.05.28-ны өдрийн 623 тоот дотоод зурвасаар санал гарган хүргүүлсэн.<br>2. Судалгаа хийсэн байдал<br>- БТКУС-ын 7005, 8426, 8429 зүйлд хамаарах зарим барааны гаалийн нэгж үнийн судалгааг сүүлийн 3 жилээр харьцуулан хийж, удирдлагад танилцуулан ГЕГ-ын холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>- БТКУС-ийн 9021.50.00 кодод ангилагдах зүрхний хэмнэл тэтгэгч аппаратын талаарх судалгааг хийлгүүлж ГЕГ-ын БДШГ-т хүргүүлсэн.<br>- Гаалийн бүрдүүлэлтийн явцад давхар нэхэмжлэх үүсгэж байгаатай холбоотойгоор 2024.11.01-2024.12.31 хүртлэх хугацаанд үүсгэсэн давхар нэхэмжлэхийн судалгааг хийж, удирдлагад танилцуулан ГЕГ-ын холбогдох нэгжид хүргүүлсэн.<br>- Импортын гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж хугацааны судалгааг 2022, 2024 оныг харьцуулан судлаж, үр дүнг төвийн даргад танилцуулан, ГЕГ-ын холбогдох нэгжид хүргүүлсэн.<br>- ГЕГ-ын дэргэдэх ГТЛ-аас ирүүлсэн зөрчилтэй 1037 дүгнэлт, тайлбартай 58 гаалийн төв лабораторийн дүгнэлтэд судалгааг хийж, үр дүнг хугацаанд нь ГЕГ-ын ГТЛ-д хүргүүлсэн.<br>- Өдөр бүрийн орлогын мэдээг татварын төрөл, гаалийн газар хороо, бүрдүүлэлтийн тоо, цэвэр жин, /мэдүүлэг, бичлэг, иргэн, ААН/ -г гарган дүн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | (34560,32 ам.доллараар мэдүүлэн 18,113,115.3 төгрөгийн гаалийн болон бусад татвар төлөхөөр мэдүүлсэн байсанд) эрсдэл тооцон ЗҮГГ-ын даргад мэдэгдэн, холбоо баригчаар дамжуулан хамтарсан манифестын лавлагаа авч 202,488,669.3 төгрөгийн гаалийн болон бусад татварыг төлүүлсэн. /Зөрүү нь 184,375,553.8 төгрөг/ | | шинжилгээ хийж, удирдлагад 16 удаа хүргүүлэн, мэдээллээр хангаж ажилласан байна.<br>3. ЗҮГГ-ын дарга, холбоо баригч ГУБ нартай холбоотой байж, хамтарсан манифестын лавлагааг 4 удаа гаргуулан хамтран ажиллаж байна. Үнээс Жинхуа орд ХХК /ГХО/-ний бөмбөлгөн бутлуурын гаалийн нэгж үнийг хянуулж 34,789,797.25 төгрөгийн гаалийн болон бусад татварыг нэмж төлүүлсэн байна. | | |
| 2. | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр | Гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>1. БЦТ-өөс аж ахуй нэгж, иргэн, мэдүүлэгч байгууллагыг эрсдэлийн зөвшөөрөгдсөн, үл хамаарах шалгууруудад хамруулах саналыг гарган судалгааны хамтаар ГЕГ-ын ЭУХ-т дотоод зуравсаар хүргүүлэн ажиллаж байна. /Тайлант хугацаанд 6 ААН-ын судалгааг хийж хүргүүлсэн/<br>2. Бичиг баримтын шалгалтад зарцуулах хугацааг бууруулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хүрээнд бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг зарим барааны бүлгээр дагнан бичиг баримтын шалгалт хийх боломжийг судлан нийт импортын гаалийн бүрдүүлэлтээс 8703, 8704-т хамаарах суудлын болон ачааны автомашин, зарим төрлийн чиргүүл, хүнд машин механизм гэж салган бичиг баримтын шалгалтыг хийх | 1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, санал боловсруулан танилцуулсан байна.<br>2. Бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж цаг хугацааг өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар бууруулсан байна.<br>3. Гаалийн бүрдүүлэлтийн | Гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>1. Гадаад худалдаа гаалийн харилцаанд оролцогч аж ахуй нэгж байгууллагын "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг боловсруулан эрсдэлийн зөвшөөрөгдсөн шалгуур болон үл хамаарах шалгуурт оруулах нийт 32 ААН-ын саналыг гарган судалгааны хамтаар ГЕГ-ын ЭУХ-т хүргүүлсэн. Үүнд: БЦТ-ийн 2025.02.26-ны өдрийн 226 тоот дотоод зурвасаар 12 ААН-ын зөвшөөрөгдсөн шалгуурт, 2 ААН-ыг үл хамаарах шалгуурт, 2025.06.03-ны өдрийн 652 дотоод зуравсаар 16 ААН-ын зөвшөөрөгдсөн шалгуурт, 2 ААН-ын үл хамаарах шалгуурт оруулах саналыг тус тус гаргаж, хүргүүлэн ажилласан.<br>2. Хөнгөлөлт, чөлөөлөлттэй гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалтыг хийх гаалийн улсын байцаагчийн тусад нь хуваарьт оруулан ээлжээр ажлуулдаг болгосон нь ГУБ нар нэгдсэн байдлаар шийдвэр гаргах, үнэлгээний нэгдмэл байдал хангагдах бүрдүүлэлтэд зарцуулагдах цаг хугацааг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой ажил болсон.<br>3. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт, хөгжүүлэлтийн саналыг МТГ-т тухай бүрт нь хүргүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>- Бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нарын CAIS програмд ажиллах эрхийн үүрэг хэсэгт "Бүрдүүлэлтийн цахим төв" гэж | 2025.01.01-2025.06.10 | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | талаарх саналыг МТГ-т хүргүүлэн шийдвэрлүүлсэн ба одоо ББГУБ нарыг ээлжээр ажлуулж байна. | автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт, хөгжүүлэлтийн саналыг тухай бүрт нь гарган, МТТ-д хүргүүлсэн байна. | үүргийг шинээр нэмүүлэх саналыг гарган, програмд өөрчлөлтийг оруулан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Дээрх үүргийн өөрчлөлтөөр амралтын өдрүүд болон бүх нийтээр амрах өдрүүдэд гаалийн улсын байцаагч нарыг тус тус хуваарилан хэвийн ажиллаж байна.<br>- БЦТ-ийн 18001281 утсаар холбогдсон ААН, иргэний дуудлагыг ГУАБ нарын эрхээр шивж бүртгэлжүүлж байсаныг дуудлага утсанд хуваарилагдан ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид өөрийн эрхээр бичиж бүртгэх эрхийн өөрчлөлтийг хийх талаар МТГ-ын ГУАБ н.Сандуйсүрэнтэй уулзаж, хөгжүүлэлтийг хэрхэн хийх талаар тохирсон, програмын хөгжүүлэлт хийгдэж байна.<br>- БЦТ-ийн 2025.03.17-ны өдрийн 271 тоот дотоод зурвасаар Кайс програмын хөгжүүлэлттэй холбоотой 3 саналыг гарган ГЕГ-ын дэргэдэх МТГ-т хүргүүлсэн. | | |
| 3. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд дараах саналыг гарган ажиллалаа. Үүнд: Журмын төслийн Гурав. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны зохицуулалт хэсгийн 3.8-д заагдсан Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэснийг Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй, бусдад дамжуулахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэж өөрчлөх.<br>2. Гаалийн бүрдүүлэлтийг алдаагүй, зөв хийхийн тулд ГБМ нартай тогтмол утсаар холбогдон заавар зөвлөгөө өгч, | 1. Шинээр батлагдсан ГБМ-ний үйл ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, хагас бүтэн жилээр засварт буцаалтад судалгаа, дүн шинжилгээ хийж, түгээмэл гаргасан алдаанд суурилсан сургалтыг 2 удаа зохион байгуулан ажиллана | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаанд гаалийн бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад тухай бүрт нь хяналт тавьж, зарим тохиолдолд харьяа гаалийн газар, хороодын ГУАБ, ГУБ нараар дамжуулан заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна. | 2025.01.01-2025.06.10 | 88 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | санал солилцон ажиллаж байна. Мөн ГБМ-т зарим анхаарах, мэдүүлэгт засвар оруулах шаардлага үүссэн үеп бичиг баримтын гаалийн улсын байцаагч нараар дамжуулан Кайс, Сепс програмыг холбосон чатаар дамжуулан өгч ажиллаж байна. | | | | |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. БТКУС-ын 68 дугаар бүлэгт хамаарах барааны гаалийн нэгж үнийн судалгаар 2024.03.01-2024.03.31 тасалбар болгон өмнөх оны мөн үетэй харьцуулан хийж, удирдлагад танилцуулан ГЕГ-ын холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>2. 2024 оны 5 дугаар сараас эхлэн БЦТ-ийн ГУАБ нарт барааны лавлах санг баяжуулах эрхийг Кайс програмд нээж өгсөн. Дээрх ажлын хүрээнд иргэн, ААН болон ГБМ нараас утсаар ирүүлсэн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгч, марк, моделийг тухай бүрт нь хурдан шуурхай Кайс програм бүртгэн, гаалийн бүрдүүлэлтийг тасралтгүй байдлыг хангаж ажиллаж байна.<br>Мөн өдөр бүрийн орлогын мэдээг татварын төрөл, гаалийн газар хороо, бүрдүүлэлтийн тоо, цэвэр жин, /мэдүүлэг, бичлэг, иргэн, ААН/ -г гарган дүн шинжилгээ хийж, ТОГ-т хүргүүлэн ажиллаж байна. | 1. Импортын барааны хэлцлийн үнийн баазыг бүрдүүлж, гаалийн үнийг бусад аргаар тодорхойлсон нийт барааны 20-аас доошгүй хувийг үнийн мэдээллийн сангийн мэдээлэлд ашигласан байна.<br>2. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж, ангиллын луйврыг илрүүлж ажилласан байна.<br>3. Барааны лавлах санг баяжуулж ажилласан байна. | Тайлант хугацаанд барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх тодорхойлох чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>1. Үнийн мэдээллийн сангийн хэлцлийн үнийн баазад 34293 үнийн мэдээлэл оруулсан байна. Үнийн нэгдмэл байдлыг хангах хүрээнд ГЕГ-ын БАҮХ-тэй тогтмол хамтран ажиллаж байна.<br>2. БТКУС-ийн 9021.50.00 кодод ангилагдах зүрхний хэмнэл тэтгэгч аппаратын талаарх судалгааг хийлгүүлж ГЕГ-ын БДШГ-т хүргүүлсэн/ААН, иргэний зүгээс БТКУС-ын буруу кодолж гаалийн байгууллагад мэдүүлэн гаалийн татвараас зугтах магадлалтай байдаг тул/.<br>3. Барааны лавлах санг баяжуулах ажлын хүрээнд иргэн, ААН болон ГБМ нараас утсаар ирүүлсэн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгч, марк, моделийг тухай бүрт нь хурдан шуурхай Кайс програм бүртгэн, гаалийн бүрдүүлэлтийг тасралтгүй байдлыг хангаж ажиллаж байна. /Програмаас нийт баяжуулалт гарахаас зөвхөн өөрийнхөө оруулсан тоог гаргах боломжгүй талаар МТГ-аас мэдэгдсэн/<br>Мөн өдөр бүрийн орлогын мэдээг татварын төрөл, гаалийн газар хороо, бүрдүүлэлтийн тоо, цэвэр жин, /мэдүүлэг, бичлэг, иргэн, ААН/ -г гарган дүн шинжилгээ хийж, удирдлагад 16 удаа хүргүүлэн, мэдээллээр хангаж ажилласан байна.<br>4. Бүрдүүлэлтийн цахим төвөөс 7 хоногийн мягмар гарагт /өнжөөд нэг удаа буюу 14 нэгт 1 удаа/ мэдээллийн цагийг тогтмол хийж, алба хаагч нарт анхаарах асуудлаар сургалт орж мэдээлэл хүргэн ажиллаж байна. Дээрх зохион байгуулагдсан сургалт, мэдээлэлд бүрэн хамрагдсан. Мөн цаг үеийн шинжтэйгээр ГЕГ-ын холбогдох нэгжүүд болон эрх бүхий байгууллагаас зохион байгуулагдсан сургалтад | 2025.01.01-2025.06.10 | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 4. Сургалт | бүрэн хамрагдан ажилласан. Тайлант хугацаанд тасалсан сургалт, мэдээллийн цаг байхгүй болно. | | |
| **Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх** | | | | | | | |
| 1. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн | Митайм ХХК-ны мэдүүлсэн барааны гаалийн нэгж үнэд эрсдэл тооцон хамтарсан манифесьыг лавлагаа авахуулсан. Өндөр үнийн дүнтэй ирсэн хамтарсан манифестын үнийн дүнгээр баримжаалан гаалийн үнийг шинээр тогтоосон ба ААН-ын зөрчлийн тухай хуулийн 11.21.12-т заасны дагуу арга хэмжээг авахуулан 2,000,000 төгрөгөөр торгосон. | 1. Мэдүүлэгчийн гаргасан алдааг илрүүлсэн тоо, нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.<br>2. Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсөн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 2 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.<br>3. Барааны ангилал, үнэлгээний луйвраас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.<br>4. Гааль зөвшөөрөв төлөвөөс | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, холбогдох хууль тогтоомж, журам зааврын хүрээнд бүрэн алдаагүй хийхэд ГУБ нарт дэмжлэг үзүүлэн, заавар чиглэлийг хуулийн хүрээнд өгч, хамтран ажиллаж байна. Мөн гаалийн бүрдүүлэлтийн явцад холбогдох хууль тогтоомж зөрчсөн болон зөрчсөн байж болзошгүй ААН, иргэний материалыг нягтлан шалгаж, мэдээллийг зөрчил хариуцсан ГУАБ, ГУБ нарт мэдэгдэн шийдвэрлүүлэн ажиллаж байна. | 2025.01.01-2025.06.10 | 89 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | засварт буцааж мэдүүлэгт засвар оруулсан байдлыг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар бууруулна. | | | |
| 2. | Өргөдөл, гомдол, маргааны г шийдвэр лэсэн байдал | Хэрэгжил т, гүйцэтгэл ээр | 1.БЦТ-ийн ГУАБ нар 7 хоногоор ээлжлэн БТКУС хариуцан гомдол мэдээллийг шийдвэрлэн ажиллаж байсан ба зохион байгуулалтын өөрчлөлт оруулан 1 сарын хугацаагаар хуваарь гарган хуваарийн дагуу ажилдаг болсон. Дээрх хуваарийн дагуу 2024 оны 6-р сард БТКУС хариуцан өргөдөл, гомдол, үнэлгээний маргааныг холбогдох хууль тогтоомж, журам зааврын хүрээнд бүрэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. 2024 оны 1-р сараас 5 сар хүртлэх хугацаанд өргөдөл, гомдолыг хариуцан ажиллахдаа tsakhimgaali@customs.gov.mn цахим хаягаар ирүүлсэн 88 гомдол, 135 хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох албан тушаалтануудтай зөвлөлдөн, хугацаанд нь хариуг нь өгч, бүрэн шийдвэрлэн ажилласан байна.<br><br>2. Шийдвэрийн мэдээллийг СЕРП програмын дуудлагын төв цэсэнд тухай бүрт нь бүрэн алдаагүй оруулан | 1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд ирсэн өргөдөл, гомдолыг холбогдох хуульд заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэн, арга хэмжээ зохион байгуулсан байна.<br>2. Шийдвэрийн мэдээллийг кайс систмеийн маргаан шийдвэрийн сан, дуудлагын төвийн шийдвэрлэх жагсаалтад бүрэн оруулсан байна. | Тайлант хугацаанд БТКУС, үнэ үнэлгээ хариуцан 1 удаа буюу 2025.05.01-2025.05.31 хүртэлх хугацаанд ажиллалаа. Ажиллах хугацаандаа БТКУС, үнэ үнэлгээ болон 18001281 утсанд хариулах алба хаагч нарыг хуваарийг 1 сараар хийж төвийн даргаар батлуулан, бүрдүүлэлтийн цахим төвд ирсэн өргөдөл, гомдол, маргаануудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүрэн шийдвэрлэн ажиллаж байна. Үүнд:<br><br>1. Гаалийн үнэ, үнэлгээ, БТКУС-ийн ангиллын кодтой холбоотой ажлууд<br><br>Нийт 142 гомдол, маргаан, хүсэлт хүлээн авч, шийдвэрлэж ажилласан. Үүнээс: 105 гомдолд "Гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдлыг хянасан тухай шийдвэр" гаргаж, бусад гомдол, хүсэлтийг тухай бүр нь шийдвэрлэж, хариу өгч ажилласан. | 2025.01.01-2025.06.10 | 96 |

| Д/д | Шийдвэрийн утга | Тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | ГУБ-ийн шийдвэр хэвээр | 54 | 51.43% |
| 2 | Үнийг дахин хянах | 41 | 39.05% |
| 3 | Хэлцлийн үнийн аргаар хянах | 8 | 7.62% |
| 4 | БТКУС код | 1 | 0.95% |
| 5 | Хүчингүй | 1 | 0.95% |
| Нийт | | 105 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүртгэлжүүлэн ажилласан байна. | | ГТГТТХ-ийн холбогдох заалтуудын дагуу гаргасан шийдвэрүүд:<br><br>1. ГТГТТХ-ийн 8.3 дахь заалт: ГУБ-ийн шийдвэр "үндэслэлтэй" гэж гаргасан 54 шийдвэрийн дунд нийт [redacted] төгрөгийн татвар нэмэгдэж, улсын төсөвт төвлөрүүлсэн.<br>2. ГТГТТХ-ийн 15.2.2.4, 15.2.2.6 дахь заалт: Гаалийн үнийг дахин хянах 41 шийдвэр.<br>3. ГТГТТХ-ийн 10.1дэх заалт: 8 шийдвэр<br>4. БТКУС-ын ангиллын код тодорхойлох: 1 шийдвэр гаргасан тус тус гарсан байна.<br>5. БТКУС-ын шийдвэр хүчингүй болсон 1 шийдвэр.<br><br>БТКУС-ын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй дараагийн шат буюу ГЕГ-ын БАҮХэлтэст хандсан нийт 5 шийдвэр байна. Үүнээс:<br><br>• Гаалийн улсын байцаагчийн шийдвэрийг хэвээр үлдээсэн – 3,<br>• Үнийг дахин хянах – 2 шийдвэр тус тус гарч, хэрэгжүүлж ажилласан.<br><br>2. Гомдол, мэдээлэл хүлээн авах цахим хаяг<br><br>Тайлант хугацаанд tsakhimgaali@customs.gov.mn цахим хаягаар 165 цахим шуудан хүлээн авсан. Үүнээс:<br><br>142 нь үнэ үнэлгээ, ангилалтай холбоотой гомдол хүлээн авсан.<br><br>✓ 105 гомдолд БТКУС-ын шийдвэр гаргасан,<br>✓ 37 гомдол, саналыг тухай бүрд шийдвэрлэсэн,<br><br>23 нь гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бусад хүсэлт,Бусад албан хүсэлтийг иргэд, ААН-тэй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдон шийдвэрлэсэн,<br>Тайлант хугацаанд ААН, иргэдээс цахим хаягаар нийт 23 албан хүсэлт ирсэн байна. Цахимаар ирүүлсэн албан хүсэлтийн утгаар нь задалвал:<br>• гаалийн бүрдүүлэлт хийхтэй холбоотой хүсэлт – 17,<br>• мэдүүлэг татгалзуулах хүсэлт – 4,<br>• татварын буцаан олголттой холбоотой хүсэлт – 2,<br>3. Гомдол, мэдээлэл хүлээн авах утас<br>БЦТ-д ирсэн дуудлагыг 2025 оны 4 дүгээр сараас 1800-1281 утсаар хүлээн авч эхэлсэн. Тус ажилтай холбоотойгоор бүртгэлийг СЕРП программд бүртгэж хэвшсэн. Тайлант хугацаанд https://cerp.ecustoms.mn/-д бүртгэсэн дуудлагын тоо 2642 байна. Үүнд:<br>• Гаалийн хяналт, бүрдүүлэлттэй хамааралтай -1558 /58,9%/<br>• Барааны ангилал, үнэлгээтэй холбоотой -651 /24,6%/<br>• Хүсэлт -287 /10,8%/<br>• Бусад -146 /5,5%/ тус тус эзлэж байна.<br>4. Зөрчлийн шийдвэрлэлтийн талаар<br>Тайлант хугацаанд ГУБ нарын илрүүлсэн зөрчлийн хэрэг хянах шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэн, зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.Үүнд:<br>• Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчил -25<br>• Харьяаллын дагуу шилжүүлсэн -20<br>• ЗГ-ын гомдол мэдээллийн 1111 төвийн гомдол мэдээллийн утсанд ирсэн 7 гомдолд хариу өгч бүртгэлийг ГЕГ-ын ХНТ-д өгч ажилласан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5. Шийдвэрийн мэдээллийг CAIS програмын гомдол, маргаан шийдвэрийн сан болон СЕРП програмын дуудлагын төв цэсэнд тухай бүрт нь бүрэн алдаагүй оруулан бүртгэлжүүлэн ажилласан байна. | | |
| **Зорилт 3: Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 1. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Бичиг баримтын шалгалтын явцад гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлагыг мөрдлөгө болгон, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн 2024.05.01-ны өдрийн ЗГ-ын 180 дугаар тогтоолоор "Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн грилын жагсаалт" батлагдсан тул тухайн жагсаалтад хамрагдах 11 БТКУС-ын кодын гаалийн бүрдүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн 2024.05.01-ны өдрийн ЗГ-ын 188 дугаар "тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор "Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай" тогтоолыг уншиж судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | 1. Горимын хэрэгжилтийг хангуулж, гаалийн бүрдүүлэлтийн хяналтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авах, түр горимын дүн шинжилгээ хийн бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагааг сажруулсан байна.<br>2. Гарал үүслийн хяналтыг сайжруулж, гаалийн бүрдүүлэлтийн явцад хөнгөлөлттэй болон нэн тааламжтай тарифыг нягтлан шалгаж, дүн шинжилгээ хийж, илэрсэн алдааг | Бичиг баримтын шалгалтын явцад гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлагыг мөрдлөгө болгон, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гаалийн бүрдүүлэлтийн явцад гарал үүслийн улсыг нотлох холбогдох бичиг баримтыг бусад шалтгааны улмаас гаргаж өгөөгүй, ердийн тариф хэрэглэн гаалийн бүрдүүлэлт хийсэн аж ахуй нэгж нь ГТГТТХ-ийн 43.2.1-д заасны дагуу ердийн тарифаас нэн тааламжтай тарифт шилжүүлэн зөрүү төлсөн гаалийн болон бусад татварыг буцаан авах хүсэлт гаргаж байна. Дээрх тохиолдолд ГЕГ-ын ХХ-ээс 2024.08.09-ний өдөр ирүүлсэн 313 тоот дотоод зурвасаар нэн тааламжтай тарифт хамруулахгүй гэж чиглэл ирүүлсэн байгааг тодруулж чиглэл өгөхийг хүссэн 2025.05.16-ны өдрийн 564 тоот дотоод зурвасыг ГЕГ-ын ТОГ-т явуулсан. Мөн шинээр гарсан ЗГ-ын тогтоол, шийдвэрийг уншиж судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2025.01.01-2025.06.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | засварлаж ажилласан байна. | | | |
| 2. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Төвийн даргын баталсан "ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарь"-ийн дагуу дараах төлөвлөгөөнүүдийг холбогдох баримт бичгүүдийн хүрээнд боловсруулан ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн.<br><br>- Төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, ажил хариуцсан ГУАБ нараас санал авч төлөвлөгөөний зарим ажилд засвар өөрчлөлт оруулан төвийн даргаар хянуулан, батлуулахаар ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн.<br><br>- Төвийн даргын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулахаар ГЕГ-т ЗУГ-т хүргүүлсэн.<br><br>- Төвийн нийт ГУАБ, ГУБ нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулан, хяналт тавьж, ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн.<br><br>2. ГЕГ-ын БАҮХ-тэй хамтран улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх төсөл, арга | 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | 1.Төвийн даргын баталсан "ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарь"-ийн дагуу дараах төлөвлөгөөнүүдийг холбогдох баримт бичгүүдийн хүрээнд боловсруулан ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн. Үүнд:<br>- Төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, ажил хариуцсан ГУАБ нараас санал авч төлөвлөгөөний зарим ажилд засвар өөрчлөлт оруулан төвийн даргаар хянуулан, батлуулахаар ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн.<br>-Төвийн даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулахаар ГЕГ-т ЗУГ-т хүргүүлсэн.<br>- Төвийн нийт ГУАБ, ГУБ нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулан, хяналт тавьж, ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн.<br>- Төвийн 2025 оны календарчилсн төлөвлөгөөг боловсруулан хянуулан, батлуулсан.<br>- Төвийн 2025 оны 1-р улирлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулан, хэрэгжилтийг нь хангаж, хугацаанд нь тайлагнан ГЕГ-ын холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.<br>- Төвийн сарын төлөвлөгөөг 2 удаа, сарын тайланг 1 удаа тус бүр хийж, хянуулан, ГЕГ-ын холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн.<br>- Төвийн 7 хоногийн төлөвлөгөө, тайланг тус бүр 9 удаа хийж, хянуулан, холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.<br>- Нийт алба хаагч нарын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үнэлгээний хуудсыг хугацаанд нь гаргаж ГЕГ-ын ХНХ-т хүргүүлсэн.<br>- Төвийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь гаргаж СЕРП-д оруулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 2025.01.01-2025.06.10 | 94 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээнүүдийн барааны ангиллын кодыг тодорхойлон ажиллаж байна. | | | | |
| 3. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн бүрдүүлэлт, холбогдох хууль тогтоомж, журам зааврыг боловсронгуй болгон ажлын хүрээнд дараах саналыг гарган ажилласан байна. Үүнд:<br>1.“Гаалийн байгууллагаас хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө”-ний төсөлд<br>2. “2024 онд олон нийтэд сурталчлах төлөвлөгөө” боловсруулан, саналыг<br>3.ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд дараах саналыг гарган ажиллалаа. Үүнд: Журмын төслийн Гурав. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны зохицуулалт хэсгийн 3.8-д заагдсан Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэснийг Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй, бусдад дамжуулахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэж өөрчлөх. | 1. Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар хугацаанд нь тайлагнасан байна.<br>2. Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна. | 1. Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж, журам зааврын хүрээнд бүрэн алдаагүй хийхэд ГУБ нарт дэмжлэг үзүүлэн, заавар чиглэлийг хуулийн хүрээнд өгч, хамтран ажиллаж байна.<br>2. Гаалийн бүрдүүлэлт, холбогдох хууль тогтоомж, журам зааврыг боловсронгуй болгон ажлын хүрээнд дараах саналыг гарган ажилласан байна. Үүнд:<br>- БЦТ-ийн 2025.04.29-ны өдрийн 467 тоот дотоод зурвасаар бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагчийн кайс програмд оруулах шалгалтын үр дүнд шинээр оруулах өөрчлөлтийн саналыг гарган ГЕГ-ын ЭУХ-т хүргүүлсэн.<br>- “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын төсөлд холбогдох 6 санал гарган 2025.04.09-ны өдрийн 358 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- 2025.02.06-ны өдрийн 159 тоот дотоод зурвасаар ГЕГ-ын ХШҮДАГ-т ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагааны шалгуурт оруулах өөрчлөлтийн саналыг гарган хүргүүлсэн.<br>- 2025.01.31-ний дрийн 139 тоот дотоод зурвасаар ГЕГ-ын ХХ-т Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд оруулах өөрчлөлтийн саналыг гарган хүргүүлсэн.<br>- Гаалийн байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөний саналыг 2024.12.23-ны өдрийн №192 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн байна. Дахин 2025 онд танхимаар зохион байгуулагдах сургалтад зарцуулагдах зардал, томилолт, цай кофе болон үдийн хоолны төсөвийн талаар саналыг 2025.01.14-ны өдрийн 48 тоот дотоод зурвасаар сургалтын төвд хүргүүлсэн.<br>- 2025.01.14-ны өдрийн 47 тоот дотоод зурвасаар ГЕГ-ын ХНХ-т “Гаалийн байгууллагын алба хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөр”-д 2 санал гарган хүргүүлсэн. | 2025.01.01-2025.06.10 | 92 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4. Соён гэгээрүүлэх** | | | | | | | |
| 1. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Нийт алба хаагчдыг үүрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах, үүрэг даалгаврын биелэлтийг хангах, удирдлагыг мэдээллээр хангах, хариуцлага хяналтыг нэмэгдүүлэхээр ажлын хуваариудыг хийж, ГУАБ нараас санал авч нэгтгэн, удирдлагад хянуулан батлуулсан.<br><br>2. Төвийн даргаас үүрэг болгосоны дагуу "Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралт"-д заагдсаны дагуу "Бүрдүүлэлтийн цахим төвийн" 4 АТТ, Гаалийн газар хорооны бүрдүүлэлтийн албаны 3 АТТ нийт 7 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан, харьцуулалт хийж, хянуулахаар ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн.<br><br>3. Албан бичгийн едок програмаар хуваарилагдан ирсэн 42 хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.<br><br>5. Үйл ажиллагаатай холбоотойгоор ГЕГ-ын холбогдох нэгжүүдээс болон удирдлагаас холбогдох хууль тогтоомжийн хүрээнд өгсөн бусад үүрэг даалгаварыг тухай | 1. ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, мэргэжлийн зөвлөл, шуурхай хуралдаанаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаварыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. | Тайлант хугацаанд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд дараах ажлуудыг хугацаанд нь бүрэн хийж хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:<br><br>1. Нийт алба хаагчдыг үүрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах, үүрэг даалгаврын биелэлтийг хангах, удирдлагыг мэдээллээр хангах, хариуцлага хяналтыг нэмэгдүүлэхээр ажлын хуваариудыг хийж, ГУАБ нараас санал авч нэгтгэн, удирдлагад хянуулан батлуулсан. Үүнд: ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарийг /байнга хариуцан ажиллах 20 ажил үүргийг нийт алба хаагчдад хуваарилсан/,<br><br>2. СЕРП-ын үүрэг даалгавар цэсээр ГЕГ-ын ХШҮДАГ-аас өгсөн 6 зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь оруулан илгээж, дүгнүүлсэн.<br><br>3. Албан бичгийн едок програмаар хуваарилагдан ирсэн 32 хүсэлт, албан бичгээс 30 хүсэлт, дотоод зурвас, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. 2 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэхээр судалж байна.<br><br>4. Бүрдүүлэлтийн цахим төвийн 2023, 2024 оны үйл ажиллагаанд ГЕГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн шаардсан тайлан, биелэлт, судалгаануудыг хугацаанд нь гаргаж өгч дүгнүүлсэн.<br><br>5. Үйл ажиллагаатай холбоотойгоор ГЕГ-ын холбогдох нэгжүүдээс болон удирдлагаас холбогдох хууль тогтоомжийн хүрээнд өгсөн бусад үүрэг даалгаварыг тухай бүрт нь хугацаанд нь бүрэн биелүүлэн ажиллалаа.<br><br>Огт биелүүлээгүй болон хугацаа хожимдуулсан үүрэг | 2025.01.01-2025.06.10 | 94 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрт нь хугацаанд нь бүрэн биелүүлэн ажиллалаа. | | даалгавар байхгүй болно. | | |
| 2. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Тайлант хугацаанд өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй ба ажлын цаг ашиглалт 100 хувь ажилласан.<br>2. Төвийн даргын баталсан хуваарийн дагуу 2024 оны 6-р сард БТКУС хариуцан ажиллахын зэрэгцээ нийт алба хаагчдын ажлын цаг ашиглалт хяналт тавин, нийт алба хаагчдын илүү цаг болон амралтын өдрөөр ажиллах, ажлын өдрөөр амрах, ажиллах хуваарийг хийж, бүртгэл хөтлөн, өдөр тутмын ирцийн мэдээг өглөө бүр гарган төвийн удирдлагад, 6-р сарын эхний хагас хугацааны цагийн бүртгэлийн гарган ГЕГ-ийн СХОХ-т тус тус хүргүүлэн ажиллаж байна. | 1.ГБ-ын хөдөлмөрийн дотоод журмын 9.3.4-т заасны дагуу "Гаалийн удирдах төв байгууллагын албан хаагч гадуур ажиллах, албан томилолтоор ажиллах, ээлжийн амралтаа эдлэх, чөлөө авах тохиолдолд харьяалах нэгжийн дарга нь Захиргаа, дотоод ажлын систем /CERP/-ийн холбогдох цэсэд хүсэлтийг илгээж ЗУГ-ын цаг ашиглалт хариуцсан ГУБ-д мэдэгдэж ажиллана.<br>2. Нэгжийн ажлын цаг ашиглалт 92 хувиас доошгүй байна. | 1. Тайлант хугацаанд өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй ба ажлын цаг ашиглалт 100 хувь ажилласан.<br>2. Төвийн даргын баталсан хуваарийн дагуу 2025 оны 5-р сард БТКУС хариуцан ажиллахын зэрэгцээ нийт алба хаагчдын ажлын цаг ашиглалт хяналт тавин, нийт алба хаагчдын илүү цаг болон амралтын өдрөөр ажиллах, ажлын өдрөөр амрах, ажиллах хуваарийг хийж, бүртгэл хөтлөн, өдөр тутмын ирцийн мэдээг өглөө бүр гарган төвийн удирдлагад хүргүүлэн ажиллаж байна.<br>3. ГБ-ын хөдөлмөрийн дотоод журмын 9.3.4-т заасны дагуу гадуур ажиллах үедээ СЕРП-ын холбогдох цэсээр хүсэлтийг илгээж, бүрэн хянуулан ажилласан. | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| 3. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. "Барааны ангилал, үнэ үнэлгээ, бүрдүүлэлтийн дараах шалгалт" сургалтын талаар ойлголт өгөх 2 цагийн сургалтыг бүрдүүлэлтийн цахим төвийн нийт алба хаагчдад хийж, мэдээ | 1. "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг 30-аас доошгүй ААН, иргэн | Гаалийн хяналт шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг боловсруулан эрсдэлийн зөвшөөрөгдсөн шалгуур болон үл хамаарах шалгуурт оруулах нийт 32 ААН-ын саналыг гарган судалгааны хамтаар ГЕГ-ын ЭУХ-т хүргүүлсэн. Үүнд: БЦТ-ийн | 2025.01.01-2025.06.10 | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилт | | мэдээллээр хангаж ажилласан. 2. “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-ийг боловсруулан төвийн даргад танилцуулж, Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024.04.12-ны 52, 2024.05.06-ны 58, 2024.05.30-ны 72 тоот дотоод зурвасуудад тусган ГЕГ-ын ЭУХ-т хүргүүлэн ажилласан байна. | бараагаар хийж ЭУХ-т хүргүүлсэн байна. | 2025.02.26-ны өдрийн 226 тоот дотоод зурвасаар 12 ААН-ын зөвшөөрөгдсөн шалгуурт, 2 ААН-ыг үл хамаарах шалгуурт, 2025.06.03-ны өдрийн 652 дотоод зуравсаар 16 ААН-ын зөвшөөрөгдсөн шалгуурт, 2 ААН-ын үл хамаарах шалгуурт оруулах саналыг тус тус гаргаж, хүргүүлэн ажилласан байна. Цаашид хяналт шалгалтаас чөлөөлөх зорилгоор эрсдэлийн зөвшөөрөгдсөн шалгуурт оруулах ААН-ын саналаас гадна эрсдэлийн заавал шалгах шалгуурт оруулах ААН, иргэний судалгааг хийж холбогдох саналын хамтаар ЭУХ-т хүргүүлэн ажиллахаар төлөвлөн зарим ААН-ын судалгааг хийж эхлүүлээд байна. | | |
| | НИЙТ | | | | | | 93.1 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д /д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор дотоод болон гадаад сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | 100 | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | 1. ГЕГ-т зохион байгуулагдсан сургалтуудад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажилласан.<br>2. Бүрдүүлэлтийн цахим төвөөс 7 хоногийн мягмар гарагт /өнжөөд нэг удаа буюу 14 нэгт 1 удаа/ мэдээллийн цагийг тогтмол хийж, алба хаагч нарт анхаарах асуудлаар сургалт орж мэдээлэл хүргэн ажиллаж байна. Дээрх зохион байгуулагдсан сургалт, мэдээлэлд бүрэн хамрагдсан. Мөн цаг үеийн шинжтэйгээр ГЕГ-ын холбогдох нэгжүүд болон эрх бүхий байгууллагаас зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдан ажилласан. Тайлант хугацаанд тасалсан сургалт, мэдээллийн цаг байхгүй болно. | 2025.01.01 - 2025.06.10 | 100 |
| 2. | Шинээр гарсан хууль тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | 100 | Хууль эрх зүйн мэдлэг сайжирч, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна. | Үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр гарсан холбогдох хууль, тогтоол, журам, заавартай танилцан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 2025.01.01 - 2025.06.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
*( Албан тушаал )*

Г.СОНОМЦЭВЭЭН /........................./
*( Нэр, гарын үсэг )*

2025. 06. 10
*( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ГАНБОЛДЫН СОНОМЦЭВЭЭНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн цахим төв

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалахийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | 57 | 9 | 66 | |
| 2. | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | 57 | 8 | 65 | |
| 3. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | 50 | 5 | 55 | |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | 57 | 9 | 66 | |
| **Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх** | | | | | |
| 1. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | 50 | 5 | 55 | |
| 2. | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал | 56 | 9 | 65 | |
| **Зорилт 3: Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | |
| 1. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | 57 | 9 | 66 | |
| 2. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 50 | 7 | 57 | |
| 3. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | 50 | 7 | 57 | |
| **Зорилт 4. Соён гэгээрүүлэх** | | | | | |
| 1. | Үүрэг даалгаврын биелэлт | 57 | 9 | 66 | |
| 2. | Ажлын цаг ашиглалт | 58 | 9 | 67 | |
| 3. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 58 | 9 | 67 | |
| | **Дундаж оноо:** | | | 62,6 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор дотоод болон гадаад сургалтад хамрагдах | 93,3 | 14 | |
| 2. | Шинээр гарсан хууль тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах | 93,3 | 14 | |
| **Дундаж оноо** | | | 14 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 7 | |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 62,6 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 91,6 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга ................................ /Э.Лхагвасүрэн/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.10 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Гаалийн улсын ахлах байцаагч ................................ /Г.Сономцэвээн/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.10 *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ /Г.Энхтайван/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.25 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч ................................ /Ө.Тэгшээ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.25 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ГЕГ-ын дарга ................................ /Р.Отгонжаргал/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.25 *(огноо)*